



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/304

Эрдэнэт

Г Улсын Онцгой комиссын  
шийдвэрийг хэрэгжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.5 “в”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 16 дугаар зүйлийн 16.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 104, 115, 118, 154 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 31, 41, 46 дугаар тушаал, 2021 оны 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл сунгаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1.1.Дээрх хугацаанд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрсөн үйл ажиллагааг нэгдүгээр, хязгаарласан үйл ажиллагааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


1.2.Байгууллага, аж ахуйн нэгжүүд [str.erdenetmc.mn](http://str.erdenetmc.mn) сайтыг ашиглан гэрийн ажиглалтад байгаа иргэдэд үйлчлэхгүй байх ажлыг зохион байгуулах, уулзалт, хурал, сургалт, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжгүй тохиолдолд байр, танхимд хүний тоог 30-аас хэтрүүлэхгүйгээр, хүн хоорондын зай 2 метрээс доошгүй байхаар зохион байгуулан өдөр бүр ариутгал халдваргүйтгэл хийж, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулахыг Шуурхай штаб (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр)-нд болон төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад даалгасугай.

2. Иргэн өөрийгөө болон олон нийт, гэр бүл, хамт олноо халдвараас хамгаалах зорилгоор Ковид-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтад идэвхтэй хамрагдаж, бүрэн тун


авсны дараа мэргэжлийн байгууллагаас тогтоосон хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг чанд баримталж байхыг аймгийнхаа нийт иргэдэд уриалсугай.

3.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр)-нд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2021 оны .05  
дугаар сарын .31.-ны өдрийн .А/304  
дүгээр захирамжийн Б хавсралт




### ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
3. Шүүх, өмгөөлөл, нотариат
4. Шатахуун, түлшний хангамж
5. Хүнс, барааны худалдаа, хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт (08.00-22.00 цагийн хооронд)
6. Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, тээвэрлэлт
7. Банк, санхүүгийн байгууллага
8. Газар тариалан, өвс тэжээл, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа
9. Харилцаа холбоо, шуудан илгээмж
10. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа
11. Хэвлэл мэдээлэл
12. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага
13. Геологи хайгуул, уул уурхай
14. Орон сууц, нийтийн үйлчилгээ, сууц өмчлөгчдийн холбоо
15. Буяны үйл ажиллагаа
16. Бүтээн байгуулалт, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл худалдаа
17. Нийтийн хоол, ресторан паб (суудлын 50%-иас хэтрүүлэхгүй, хүн хоорондын зай 2 метрээс доошгүй байх, 08.00-22.00 цагийн хооронд)
18. Үсчин, гоо сайхан нийтийн ахуй үйлчилгээ (цаг олгож үйлчлэх)
19. Чийрэгжүүлэх, бялдаржуулах болон алжаал тайлах төв, саун, бассейн (хүчин чадлын 50%-иас хэтрүүлэхгүй, хүн хоорондын зай 2 метрээс доошгүй байх)
20. Сүм хийдийн цугларалт, уншлага (суудлын 50%-иас хэтрүүлэхгүй, хүн хоорондын зай 2 метрээс доошгүй байх)
21. Зочид буудал, дэн буудал, амралтын газар (тусгаарлах байраар ашиглаж байгаагаас бусад)
22. Хотын доторх болон хот хоорондын зорчигч тээвэр (www.erdenet.mn цахим хуудсанд бүртгүүлж зөвшөөрөл авсан байх)-ийн үйлчилгээ (1 суудал алгасан 1 зорчигч суулгах)
23. Сонгуулийн бүх шатны үйл ажиллагаа

Жич: - Хязгаарлах үйл ажиллагааны жагсаалтад ороогүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцно.

- Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдөж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажиллагсад нь дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан байх

Аймгийн Засаг даргын 2021 оны <sup>05</sup>  
дугаар сарын <sup>31</sup>-ны өдрийн <sup>А/309</sup>  
дүгээр захирамжийн II хавсралт



### ХЯЗГААРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан
2. Спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн, аялал зугаалга (гэр бүлийн гишүүдийн хүрээнээс бусад), хурим найр
3. Диско баар, караоке
4. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар
5. Үзвэр үйлчилгээ, нийтийн бүжиг, соёл урлаг (цахимаар болон зайнаас зохион байгуулахаас бусад)

\_00\_